



## МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2015 оны 02 сарын 10 өдөр

Дугаар 43

Улаанбаатар хот

### Арилжаанд оролцох эрхийг сэргээх тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1, “Монголын хөрөнгийн бирж” төрийн өмчит хувьцаат компанийн Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.10.11, Гүйцэтгэх захирлын 2015 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн 42 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Ард капитал групп” ХХК, “Монсек” ХХК, “Эм ай си си” ХХК-иудын арилжаанд оролцох эрхийг 2015 оны 2 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн сэргээсүгэй.
2. Цаашид хууль тогтоомж, журам заавар болон “Монголын хөрөнгийн бирж” төрийн өмчит хувьцаат компанитай байгуулсан “Хамтран ажиллах гэрээ”-ээр хүлээсэн үүргээ тогтмол биелүүлэн ажиллахыг тушаалын 1-д заасан үнэт цаасны компаниудад анхааруулсугай.
3. Тушаалын биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Арилжаа, хяналтын алба /М.Энхтуяа/-д үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН  
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Д. АНГАР